

.....сургуулийн.....ангийн сурагч..... овогтой.....

“А” ХУВИЛБАР

80 МИНУТ

Арслангийн бууны нохой болж хувирах нь ээ

Дэлхийн хамгийн хурдан амьтан бол улаан ирвэс юм. Тэр огцом ухасхийхдээ 110км/цаг буюу бидний хэлж дадсанаар 110 милл хурдалж чаддаг байна. Энэхүү рекордыг одоохондоо “мөчит дөрвөн хөлт ” ямар ч амьтан эвдэж чадаагүй байгаа юм.

Улаан ирвэс уг нь мийн овгийнх. Энэ овгийн бар, ирвэс, муурууд бүгд гэтэгч амьтан. Ганцхан улаан ирвэс л довтлогч бөлгөө. Энэхүү хурдлагч муурын бие нь зэгзгэр, хөл нь өндөр байх аж. Шаравтар, зузаан үстэй, элсэрхэг шар бие битүү хар цагирган толботой. Урт сүүлтэй. Сүүл нь том толботой. Улаан ирвэс уулын хүйтэн орчинд дасан зохицсон, бие бахим, чих жижиг дугуй байдаг тул дулаан бага алддаг. Тавхай өргөн байдаг нь цасан дээр явахад жингээ жигд хуваарилахад хэрэгтэй бөгөөд тавхайндаа үстэй байдаг нь эгц, тогтворгүй гадаргуу дээр явахад тусалдгаас гадна дулаан алдагдлыг багасгадаг. Нас бие гүйцсэн ирвэс муурын төрлийн бусад амьтантай адил 30 шүдтэй. Түүний урт хэл нь “цэвэрлэгээ”-нд их хэрэгтэй. Улаан ирвэс нь 18-20 жил амьдардаг. Жирийн үед муур шиг дуугарах бөгөөд уурлахдаа харин хүрхэрч, архирна. Ирвэсний арьсан дээрх толбо нүдтэй адил харагддаг байна. Ихэвчлэн шөнийн цагаар ангуучилдаг тул хараа, сонсголын эрхтэн маш сайн хөгжсөн. Дунджаар хагас сард нэг удаа том ан хийж түүгээрээ 4-5 хоног хооллодог. Үржлийн үеийг эс тооцвол ганцаараа амьдардаг байна.

Хурдлах чадвар нь нурууны байгууламжтай их холбоотой. Уян хатан нугаламын ачаар нуруу нь маш сайн нумарч тэнийж, тэр эрчээр бие 7-8 м хол шидэгдэж чавхны чулуу лугаа адил одно. Бултаж буй амьтантай зэрэг шахам чиглэлээ өөрчлөх нь ямар ч уургын мориноос илүү. Урт сүүл нь биеийн эсрэг савлаж тэнцвэржүүлдэг. Түүний зүрх, уушги, хамрын нүх нь бүгд багтаамж сайтай. Ийм амьтан талын гөрөөс туулайг цахилах мэт хурдан авлана. Авласны дараа мөн тун түргэн идэх шаардлагатай. Яагаад гэвэл арслан, цөөвөр чононууд түүнийг нүд салгахгүй харж байдаг. Гөрөөс хаана “тоос татуулсан” тэр газар луу анч нохойныхоо араас ирж байгаа анчид шиг давхилдацгаана. Хоолыг нь булаацалдан зодолдоно. Бушуухан хэд үмхэж аваад л зайгаа тавихгүй бол хүчирхэг араатнууд өөрийг нь хоёр хуваачхаж дөнгөх билээ. Ялангуяа ан хөөгөөд гүйцэхээ байсан хөгшин арслангууд улаан ирвэс хаана юу муучлахыг хариулж суудаг ажилтай болдог нь дэндүү гомдмоор хэрэг юм. Түүний анч нохой нь болж хувирах нь байна шүү дээ.

Эцэст нь хэлэхэд энэхүү ирвэс Африк болон өмнөд, дундад Азид амьдарна. Тал нутагт бас цөлд ч амьдарч чаддаг ажээ. Ж.

Мягмарсүрэн

1. Улаан ирвэсийг ямар учраас хурдлагч муур гэж нэрлэсэн вэ?

.....

2. Улаан ирвэс ан авласны дараа түргэн идэх шаардлагатай болдгийн учир юу вэ?

.....

3. Улаан ирвэс хөгшин арслангуудын анч нохой болж байгаагийн шалтгааныг тайлбарлан бичнэ үү.

.....

4. Улаан ирвэс хамгийн хурдан амьтан гэдгийг 3 баримтаар батлан бич.

.....
.....
.....
.....
.....

5. Дараах хэлц үгсийн утгыг тайлбарлан бичээрэй.

зайгаа тавих-.....

нүд салгахгүй-.....

уургын морь-.....

6.Гэтэгч, довтлогч гэж нэрлэсний учрыг 50-60 үгэнд багтаан тайлбарлан бичээрэй.

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

7. Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй.

ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ
ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ
ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ
ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ
ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ
ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ
ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ
ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ	ᠮᠠᠨᠤ

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

8. Дээрх “Арслангийн бууны нохой болж хувирах нь ээ” эхэд ирвэс нь гайхамшигтай хурдлах чадвартай болох тухай баримттай өгүүлжээ. Эхийн найруулгын арга хэлбэрийг ашиглан “Миний мэдэх ховордож буй амьтан” сэдвээр 180-200 үгэнд багтаан эх зохион бичээрэй. Бичихдээ дараах агуулгын бүтцийг ашиглаж болох юм.

- **Эхлэл хэсэг:** Өөрийн сайн мэдэх ховордож буй амьтнын талаар мэдээлэл өгөх
- **Гол хэсэг:** Тухайн амьтан ямар шалтгааны улмаас цөөрч байгааг батлан бичих
- **Төгсгөл хэсэг :** Монгол оронд ховордож буй амьтдаа хайрлан хамгаалах талаар өөрийн бодлыг бичиж төгсгөх

МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ/ 9-Р АНГИ/

.....сургуулийн.....ангийн сурагч..... овогтой.....

“Б” ХУВИЛБАР

80 МИНУТ

Ганц үг гавхийдэггүйн учир

Дэлхий дээрх амьтдаас хамгийн өндөр нь яах аргагүй анааш юм. Африкийн ширэнгэ ойд амьдардаг энэ амьтны өндрийг эрдэмтэд бараг зургаан метр хүрнэ гэж үздэг. Ялангуяа түүний хөл хүзүү хоёр нь яахлаараа ингэж суначихдаг байна аа гэмээр урт. Анааш модны орой хавийн навч шилмүүсээр хооллодог. Тийм учир үргэлж өөдөө тэмүүлж амьдардгийн үр дүнд ийнхүү их өсгөлүүн болсон юм гэж зарим хүн ярьдаг. Бүх л эрхтэн нь дээшээ ургаж хоол руугаа тэмүүлжээ. Хэл нь навчинд хүрэх гэж сунасаар байгаад түүний урт нь 40 см –ээс ч илүү сунадаг бололтой.

Толгой жижиг. Урт хүзүүний үзүүрт толгой гэж ялгагдаад байх юм бараг байхгүй. Бас хоёр сөөсгөр үсэн эвэртэй. Харин ойрхноос харж чаддагсан бол хөөрхөн дүрлэгэр хар нүд битүү намирах сормосгон доороо тунарч байдаг байна. Түүний өнгө зүс нь ерөнхийдөө ухаа шаргал дэвсгэр дээр хүрэн бор өнгийн толбонуудтай. Энэ толбонууд нь хэдэн мянган жилд түм буман анааш төрөхөд нэг ч давтагддаггүй онцлогтой юм гэдэг.

Анааш доошоо тонгойж хоол олж идэх нь ховор. Хэрэв хааяа нэг амттан газраас зооглох болбол гарцаагүй өвдөглөж сөгдөхөд хүрдэг байна. Харин ус уухдаа тулбал урд хоёр хөлөө хоёр тийш нь сайн алцайлган тэлж намхан болж байж усандаа хүрнэ. Ийнхүү зовлонтой тонгойдгоосоо болоод ч тэр үү анааш хэдэн долоо хоног ус ч амсалгүй идсэн ургамлынхаа шүүсээр аргацаагаад байж чаддаг байж магадгүй юм. Тэд нийлж сүрэглэж амьдарна. Өглөө, оройн сэрүүнд ихээхэн идэвхтэй идшилж шөнө ялимгүй жаахан дугхийгээд авдаг байна. Тэгж унтахдаа их сонин. Аюул багатайхан ойн цоорхой олж урд хөлөө өвдгөөр нь нугалж харин хойд хөлийнхөө аль нэгийг хажуу тийш нь жийж урт хүзүүгээ гэдрэг нугалан жийсэн хөлийнхөө ард толгойгоо тавьж түр зуур дуг хийдэг байна. Нэг ёсондоо унтаж байгаа анаашны духыг илэх шаардлага гарвал толгойг нь биеийнх нь ард тэмтрэх шаардлага гарах нь байна. Ингэж их ажил болж болж хэвтсэн атлаа 10-20 минут уртдаа 1 цаг гаруй нойр аваад босоод ирдэг байна.

Анааш их л найрсаг эвтэй амьтад. Хэрүүл зодоон бараг хийхгүй. Яагаад гэвэл тэд үг дуу маш цөөтэй. Зэрэг зиндаагаа ч сайн мэднэ. Басхүү хүчтэнийхээ өмнүүр хүчгүй нь зам хөндөлсөн гарна гэж үгүй. Бие биедээ урт хүзүүгээ доошлуулж толгой гудайлган хүндэтгэл үзүүлдэг. Харин сүргийн толгойлогч нарын хооронд хааяа зодоон болно. Тэд зодолдохдоо бас л өвөрмөц. Өөд өөдөөсөө харан хөлөө алцайлгаж цээжээ өвчүүгээр нь шахан нийлүүлж бат суурьтай зогсож авсныхаа дараа нөгөө урт хүзүүгээрээ бие биеэ шавхуурдан ороолгоно. Буурцган чинээ толгойгоо салтал шавхуурдацгаана. Тэгээд хэн их хүчтэй шавхуурдаж нөгөөгийнхөө хүзүүг өвтгөж чадсан нь ялагч болно. Ялагдсан нь хажуу тийшээ 2-3 алхам номхрон зогсож ялагчдаа ая тал засна. Яаж ая тал засах вэ гэхлээр нөгөөгийнхөө урт хүзүүт толгойг нуруун дэрээ тавиулж амраах гэх мэтээр. Түүнээс ялагдсаныгаа хөөх юм уу, хатуу туурайгаараа цавчих гэх мэтийн айхтар дайсагналцал үл гаргана.

Урт хэл хүзүү орооно хэмээх манайхны зүйр цэцэн үг байдаг. Анашинд тийм юм ёстой байхгүй .Тэр харин урт хэлээ ашиглаж хэлээрээ газар ухаж чаддаг байна. Түүнээс бус илүү дутуу дуугарна гэж үгүй. Түүний хэл хүзүүгээ хоёр ч ороохоор урт боловч хэл амнаасаа болж баларна гэсэн ойлголт байхгүй. Яагаад гэвэл тэр амьдралдаа нэг ч удаа дуугардаггүй юм. Ганц үг ганхийлгүй хорь шахам жил хорвоо дээр тоос хөдөлгөдөг байна.

Ертөнцийн сайн муу үйл бүхэн зөвхөн үгнээс үүддэг гэлцэнэ.
Ж.Мягмарсүрэн

1. Дэлхий дээрх хамгийн өндөр амьтны хоол тэжээлийг нэрлэнэ үү.

2. Ганц үг гавхийдэггүй амьтны гадаад, дотоод шинжийг тоочин бичнэ үү.

Засагч багш нарт:

-Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, өгөгдсөн түлхүүрийг зөвлөмж болгон ашиглана.

-Оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

-Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7-даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Оноо өгөх зарчим:

Даалгавар 1. Нийт 1 оноо

Эхэд өгүүлснээр хоол тэжээлийг зөв тодорхойлсон бол 1 оноо

- Анааш модны орой хавийн навч шилмүүсээр хооллодог.

Даалгавар 2. Нийт 2 оноо

Амьтны гадаад, дотоод шинжийг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон бол 2 оноо

Амьтны гадаад, дотоод шинжийг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон боловч, өөр өгүүлбэр хамт бичсэн эсвэл цогцолбороор нь авсан бол 1 оноо

Амьтны гадаад, дотоод шинжийгилэрхийлэх өгүүлбэрийг олж чадаагүй бол 0 оноо

- Толгой жижиг. Урт хүзүүтэй, бас хоёр сөөсгөр үсэн эвэртэй, дүрлэгэр хар нүд битүү намирах сормостой. Өнгө зүс нь ерөнхийдөө ухаа шаргал дэвсгэр дээр хүрэн бор өнгийн толбонуудтай.
- Найрсаг эвтэй амьтад. Хэрүүл зодоон бараг хийхгүй. Яагаад гэвэл тэд үг дуу маш цөөтэй. Зэрэг зиндаагаа ч сайн мэддэг.

Даалгавар 3. Нийт 2 оноо

Эхээс таамагласан өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэрийг зөв олсон бол 2 оноо

Эхээс таамагласан өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэрийг 1-ийг олсон бол 1 оноо

Эхээс таамагласан өнгө аястай өгүүлбэрийг олоогүй эсвэл өөр өгүүлбэр олсон 0 оноо

- Хэл нь навчинд хүрэх гэж сунасаар байгаад түүний урт нь 40 см –ээс ч илүү сунадаг бололтой.
- Ийнхүү зовлонтой тонгойдогтоо ч болдог юм уу анааш хэдэн долоо хоног ус ч амсалгүй идсэн ургамлынхаа шүүсээр аргацаагаад байдаг байж магадгүй юм.

Даалгавар 4. Нийт 3 оноо

Хэлцийн утгыг зөв тайлбарлан бичсэн бол 1 оноо

- зусардах, бялдуучлах,
- хүний байр байдалд тохируулах, нэлээд бэлтгэх,
- огт дуу гарахгүй байх

Даалгавар 5. Нийт 3 оноо

Эхээс дайсагнал үүсгээд байдаггүй шалтгааныг зөв олж бичсэн болон дутуу олсноос шалтгаалан 1-3 хүртэлх оноог тохируулан өгнө.

Шалтгааныг огт олоогүй эсвэл шалтгааныг илэрхийлсэн өгүүлбэр олоогүй бол 0 оноо

- Эвсэг найрсаг амьтан. Хэрүүл зодоон бараг хийхгүй. Яагаад гэвэл тэд үг дуу маш цөөтэй. Зэрэг зиндаагаа ч сайн мэднэ. Басхүү хүчтэнийхээ өмнүүр хүчгүй нь зам хөндөлсөн гарна гэж үгүй. Бие биедээ урт хүзүүгээ доошлуулж толгой гудайлган хүндэтгэл үзүүлдэг. Ялагдсан нь хажуу тийшээ 2-3 алхам номхрон зогсож ялагчдаа ая тал засна. Яаж ая тал засах вэ гэхлээр нөгөөгийнхөө урт хүзүүт толгойг нуруун дэрээ тавиулж амрах гэх мэтээр.

Даалгавар 6. Нийт 4 оноо

Асуудал дэвшүүлэн хүүрнэн бичсэн байдлаас 1-4 оноог тохируулан өгөх

Бичээгүй бол 0 оноо

Даалгавар 7. Нийт 5 оноо

Бүгдийг зөв хөрвүүлсэн бол 5 оноо

1-2 үг алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

3-4 үг алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

5-6 үг алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

7-8 үг алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

9 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

Даалгавар 8. Нийт 20 оноо

агуулга	оноо өгөх заавар	оноо
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж, эхийг бүхэлд нь учир шалтгааны уялдаа холбоотой бичсэн бол	5
	Учир шалтгааны уялдаа холбоо, цаг хугацаа, үйл явдлын дараалал бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч сэдвийн дагуу бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл нэг үйл явдлыг биш хэд хэдийг бичсэн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Дүр дүрслэл	Дүр, дүрслэлийг оновчтой ашигласан бол	2
	Оновчтой биш ч дүрслэх ур маяг ашигласан бол	1
	Дүрслэх ур маяг ашиглаагүй, хүний хэлсэн үг зэрэг нь ялгарч мэдэгдэхээргүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэв маяг	Эх бүхэлдээ хүүрнэсэн өнгө аястай бол	2
	Эхийн ихэнх хэсэг хүүрнэсэн бол /дүр, орчноо танилцуулах гээд хэт их тоочих зэрэг алдаа гарсан бол/	1
	Эх бүхэлдээ өөр хэв маягтай бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	3
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй бол	3
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	180-210 хооронд бол	1
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	3
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	1
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X

Засагч багш нарт:

-Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, өгөгдсөн түлхүүрийг зөвлөмж болгон ашиглана.

-Оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

-Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7-даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Оноо өгөх зарчим:

Даалгавар 1. Нийт 1 оноо

Улаан ирвэсийг хурдлагч муур гэж нэрлэсний учрыг зөв тодорхойлсон бол 1 оноо

- Улаан ирвэс дэлхийн хамгийн хурдан амьтан.

Даалгавар 2. Нийт 2 оноо

Барьсан ангаа хурдан иддэгийн учрыг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон тайлбарласан бол 2 оноо

Дутуу олсон тайлбарласан бол 1 оноо

Буруу өгүүлбэр бичсэн огт бичиж чадаагүй бол 0 оноо

Арслан, цөөвөр чононууд түүнийг нүд салгахгүй харж байгаад барьсан анг нь булаан иддэг учраас.

Даалгавар 3. Нийт 2 оноо

Эхээс шалтгааныг илэрхийлсэн өгүүлбэр зөв олсон бол 2 оноо

Эхээс шалтгааныг илэрхийлсэн өгүүлбэр 1-ийг олсон бол 1 оноо

Эхээс шалтгааныг илэрхийлсэн өгүүлбэрийг олоогүй эсвэл өөр өгүүлбэр олсон 0 оноо

- Хоолыг нь булаацалдан зодолдоно.
- Бушуухан хэд үмхэж аваад л зайгаа тавихгүй бол хүчирхэг араатнууд өөрийг нь хоёр хуваачихаж дөнгөх билээ.

Даалгавар 4. Нийт 3 оноо

Баримтыг зөв олж бичсэн бол 1 оноо

Буруу өгүүлбэр бичсэн эсвэл огт бичээгүй бол 0 оноо

- Огцом ухасхийхдээ 110км/цаг хурдалж чаддаг байна,
- Энэхүү рекордыг одоохондоо “мөчит дөрвөн хөлт ” ямар ч амьтан эвдэж чадаагүй,
- Нурууны байгууламжтай их холбоотой, Уян хатан нугаламын ачаар нуруу нь маш сайн нумарч тэнийж чаддаг.

Даалгавар 5. Нийт 3 оноо

Хэлцийн утгыг зөв тайлбарлан бичсэн бол 1 оноо

Огт бичээгүй бол 0 оноо

- байр сууриа тавьж өгөх, чөлөөлж өгөх,
- юмыг шимтэн үзэх,
- ямарваа нэг үйл хийхдээ маш сайн

Даалгавар 6. Нийт 4 оноо

Асуудал дэвшүүлэн хүүрнэн бичсэн байдлаас 1-4 оноог тохируулан өгөх

Бичээгүй бол 0 оноо

Гэтэгч амьтад нь ангахаар сэмээр мяраан ойртон гэтэж байгаад ангаа барьдаг. Довтлогч гэдэг нь шууд дайран довтлох маягаар ангаа барьдаг... Гэх мэт

Даалгавар 7. Нийт 5 оноо

Бүгдийг зөв хөрвүүлсэн бол 5 оноо

1-2 үг алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

3-4 үг алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

5-6 үг алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

7-8 үг алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

9 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

Даалгавар 8. Нийт 20 оноо

агуулга	оноо өгөх заавар	оноо
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж, эхийг бүхэлд нь учир шалтгааны уялдаа холбоотой бичсэн бол	5
	Учир шалтгааны уялдаа холбоо, цаг хугацаа, үйл явдлын дараалал бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч сэдвийн дагуу бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл нэг үйл явдлыг биш хэд хэдийг бичсэн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Дүр дүрслэл	Дүр, дүрслэлийг оновчтой ашигласан бол	2
	Оновчтой биш ч дүрслэх ур маяг ашигласан бол	1
	Дүрслэх ур маяг ашиглаагүй, хүний хэлсэн үг зэрэг нь ялгарч мэдэгдэхээргүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэв маяг	Эх бүхэлдээ хүүрнэсэн өнгө аястай бол	2
	Эхийн ихэнх хэсэг хүүрнэсэн бол /дүр, орчноо танилцуулах гээд хэт их тоочих зэрэг алдаа гарсан бол/	1
	Эх бүхэлдээ өөр хэв маягтай бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	3
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй бол	3
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	180-210 хооронд бол	1
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	3
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	1
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X